



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8/03

Хэрлэн сум

**С.Чулуунцэцэгийг түр орлон
гүйцэтгэгчээр томилох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, 67.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн Нярав Т.Баяртуяа нь жирэмсний болон амаржсаны амралт авсан тул Санхүү, төрийн сангийн хэлтсийн Дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн Соёлмаагийн Чулуунцэцэгийг Няравын албан тушаалд 2024 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

2. С.Чулуунцэцэгийн ажлыг хүлээлцүүлэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	С.Нямдаваа	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
Гишүүд:	Д.Цэцэгсүрэн	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч
	Д.Энхтуяа	Архив, Бичиг хэргийн эрхлэгч

3. С.Чулуунцэцэгт няравын ажлыг түр орлон гүйцэтгэсний цалинг үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгохыг Нягтлан бодогч (Х.Баярбаатар)-д зөвшөөрсүгэй.

4. Байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг болон хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг С.Чулуунцэцэгт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНТУЛГА